## III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДЭД
ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 08 дугаар сарын 28 өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Захиалагч байгууллага | Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс |
| 2. | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт |
| 3. | Байршил | Чингэлтэй дүүрэгт |
| 4. | Үйлчилгээ үзүүлэх хугацаа | 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртлэх |
| 5. | Үйлчилгээний цар хүрээ | Чингэлтэй дүүргийн нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ"- зөвлөгөө өгөх үйлчилгээ, , хууль, журамд, аргачлал, гэрээнд үүргийн дагуу чанартай сайн гүйцэтгэх. |
| 6 | Ажлын зохион байгуулалт | 1.Захиалагч үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргаж гүйцэтгэгчид өгсний дараа үйлчилгээг эхлүүлнэ.<br>2.Гүйцэтгэгч үйлчилгээг үзүүлэхдээ зорилтот бүлгийн иргэний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг л санал болгож ажиллана.<br>3.Гүйцэтгэгч байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг үйлчилгээ үзүүлэх хугацаанд чанд мөрдөж ажиллана.<br>4.Үйлчилгээг гүйцэтгэхэд шаардсан боловсон хүчин нь ажил эхэлснээс дуусах хүртэлх хугацаанд өөр бусад байгууллагад ажиллахгүй.<br>5.Үйлчилгээ үзүүлэх байгууллага нь байгууллагын товч танилцуулга, үйлчилгээний талаарх мэдээлэл, харилцах утас, хаяг байршлын талаарх мэдээллийг самбарт байршуулж ажиллана.<br>6.Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эд хогшил, бараа материал, багаж, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг бүрэн хангасан байна.<br>7.Гүйцэтгэгч байгууллага нь иргэдэд үйлчилгээг үзүүлэхдээ хэт их ачаалал үүсгэхгүйгээр батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, сар бүрээр тайланг гаргаж, захиалагчид хүргүүлнэ. |
| 7 | Бусад | Гэрээт хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилтийг дүгнэж акт үйлдэнэ. |